



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/107

Бат-Өлзий сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай


Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 3-р багийн нутаг дэвсгэрт Цаг-Уур-1-ын 101 тоот хаягт байрлах 6221000347 нэгж талбарын дугаартай Өвөрхангай аймгийн ус, цаг уур, орчны шинжилгээний төв (РД:3550192)-ын цаг уурын байнгын ажиглалтын талбайн зориулалттай 686 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр сунгасугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бат-Өлзий сумын Засаг даргын 2005 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 44 дүгээр захирамжаар олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН